



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН,
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

14201 Улаанбаатар хот-4ба ш/х-600
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 3,
Утас: 32-56-31, Факс: (976-11) 32-56-31,
И-мэйл: dean@seas.num.edu.mn, Вэб: <http://seas.num.edu.mn>

ХОВД ИХ СУРГУУЛЬ-Д

2022.09.16 № 01

Санал хүргүүлэх тухай

Ховд Их Сургуулийн Химийн тэнхимийн “Хотын экологи” хичээлийн хөтөлбөртэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

1. Тус хичээлийн агуулга нь хотын экологи болон экосистемийн асуудлуудын талаар үндсэн ойлголтыг өгөхийн зэрэгцээ хотын тогтвортой хөгжил, байгальд түшиглэсэн ухаалаг хот, экосистемд суурилсан дасан зохицохуй болон хотын байгальд суурилсан шийдлүүд зэрэг орчин үед дэлхий дахинаа анхаарал хандуулж буй сэдвүүдийг тусгаж өгсөн нь өнөөгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байна.
2. Хотын орчны бохирдол, хог хаягдлын асуудал болон эдгээрийг бууруулах арга замуудыг дасгал ажлын хичээлээр сургаж, хэрэглээний дадлага чадварыг эзэмших боломжийг суралцагсад олгохоор тусгасан нь хичээлийн ач холбогдлыг нэмэгдүүлсэн оновчтой төлөвлөлт болжээ.
3. Хичээлийн хүрээнд заагдах сэдвүүдийн дэс дараалал тохиромжтой байна.
4. Хотын экосистемийн үйлчилгээг тооцох аргачлал, хот суурин газрын ногоон байгууламжийн төлөвлөлт, хотын эко орчинг төлөвлөх загвар гаргах, төлөвлөлтийн оновчтой шийдлүүдийг нэмж оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Санал бичсэн:

МУИС, ХШУИС-ийн ХБОИТ-ийн багш, дэд проф.

Н.Оюунчимэг